

"Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 24/12 тоот  
тогтоолын Нэгдүгээр хавсралт



## **"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН "ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО"**

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	1
ХОЁР. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ .....	1-2
ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ СУРГАЛТ, ХӨГЖИЛ .....	2
ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ .....	2-3
ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ .....	3

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Залгамж халааны бодлого” (цаашид “Бодлого” гэх)-оор Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, сонгох, залгамж халаа бэлтгэх, сургаж хөгжүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх харилцааг зохицуулна.
- 1.2. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, гэнэтийн болон төлөвлөгдөөгүй өөрчлөлтөд бэлэн байх зорилгоор энэхүү бодлогод нийцүүлэн Гүйцэтгэх захирал нь эрх бүхий албан тушаалтны залгамж халааны төлөвлөлтийг хийж хэрэгжүүлнэ.

### ХОЁР. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ

- 2.1. ТУЗ-ийн гишүүн болон компанийн удирдах ажилтанд нэр дэвшүүлэх:
  - 2.1.1. ТУЗ-ийн дэргэдэх “Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо” /цаашид “Хороо” гэх/ нь ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тогтоох, шаардлагатай зөвлөмжийг боловсруулна;
  - 2.1.2. Хороо нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчдэд урьдчилсан үнэлгээ өгнө;
  - 2.1.3. ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагын ажил үүргийн тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хянаж, үнэлэлт дүгнэлт өгнө;
  - 2.1.4. Энэ журмаар тодорхойлсон ТУЗ-ийн гишүүний хараат бус байдлыг тодорхойлох шалгуурыг хянан үзэх, хараат бус эсэх (эсвэл хараат байдлын) талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй;
  - 2.1.5. Шинээр сонгогдсон гишүүдэд ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдээлэл өгч, удирдамж, зааварчилгаагаар хангана;
  - 2.1.6. Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны залгамж халааг бэлдэх төлөвлөгөө, хэрэгжүүлэх бодлогыг хянаж, зөвлөмж өгнө.
- 2.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь доорх шалгуурыг хангасан байна:
  - 2.2.1. Удирдах албан тушаалд ажиллаж байсан туршлагатай;
  - 2.2.2. Санхүү, эдийн засаг, бизнес, хууль, холбогдох бусад салбар, шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй;
  - 2.2.3. Ёс зүй, зан суртахууны өндөр хэм хэмжээг баримталдаг;
  - 2.2.4. ТУЗ-ийн гишүүний ажил үүргийг гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой бөгөөд хүсэлтэй;
- 2.3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:
  - 2.3.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшдэггүй;
  - 2.3.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
  - 2.3.3. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
  - 2.3.4. Компанитай бизнесийн аливаа холбоогүй;
  - 2.3.5. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.
- 2.4. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь дараах сонгон шалгаруулалтын зарчмыг баримтална:



- 2.4.1. ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдлын тэнцвэрийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй ажилладаг бүтэц бүрэлдэхүүнтэй байна;
- 2.4.2. Нэр дэвшигчдийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг зэргээр ялгаварлан гадуурхахгүй;
- 2.4.3. Хүйсийн зохистой харьцааг хангахыг зорино. Ингэхдээ ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн эзлэх хувь 30 (гуч)-аас доошгүй байлгахыг эрмэлзэнэ;
- 2.4.4. Компанийн нэр хүнд, ашиг сонирхолд харшлах этгээдийг нэр дэвшигчээр сонгохгүй;
- 2.4.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрвөн) сарын дотор зарлан хуралдуулаагүй үндэслэлээр аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсноос хойш 3 (гурван) жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзана.
- 2.5. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь шаардлага хангасан нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхэд дараах журмыг мөрдөнө:
- 2.5.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана;
- 2.5.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй этгээдийн хараат бус байдлыг хэрхэн тодорхойлсон, бусад компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг эсэх талаар дэлгэрэнгүй танилцуулна;
- 2.5.3. ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшиж буй этгээд нь нэр дэвших хүсэлт, сонгогдсон тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой, хүсэл тэмүүлэл бий гэдгээ бичгээр илэрхийлснийг шалгана;
- 2.5.4. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгоход ТУЗ-ийн гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, ТУЗийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээллийг танилцуулна;
- 2.5.5. ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгоно;
- 2.5.6. ТУЗ-ийн гишүүн нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн тохиолдолд Нэр дэвшүүлэх хороо яаралтай хуралдаж, орлох этгээдийг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу томилгоог албажуулна.

### **ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ СУРГАЛТ, ХӨГЖИЛ**

- 3.1. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба чиглүүлэх хөтөлбөр нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох сургалтын агуулгатай байна.
- 3.2. ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, чадварыг тогтмол дээшлүүлэх, цаг үеийн мэдээллийг олгоход Компанийн зүгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ба тус сургалтын хөтөлбөрийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо баталж, ТУЗ-ийн ажлын албанаас зохион байгуулна.
- 3.3. ТУЗ-ийн гишүүнд зориулсан сургалт нь зайны, танхимын болон рэтрийт, бизнес аялал хэлбэртэй байж болно.
- 3.4. Сургалтын зардлыг компани бүрэн хариуцна.

### **ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ**

- 4.1. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд Нэр дэвшүүлэх хороо дүгнэлт өгнө.

4.2. Нэр дэвшүүлэх Хороо нь ТУЗ-ийн гишүүний хувьд ТУЗ-ийн болон Хорооны хурал болон ТУЗ-өөс урилга хүргүүлсэн хурал, зөвлөгөөн, семинарт оролцсон байдал, ТУЗ-өөс болон холбогдох Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн зэрэг үзүүлэлтийг харгалзан дүгнэлт өгөх бөгөөд “ТУЗ-ийн гишүүдийн үйл ажилагаанд дүгнэлт өгөх хуудас”-ыг боловсруулан ашиглана.

4.3. ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, Хороодын дарга нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг жил бүрийн 1 дүгээр улирлын хуралд танилцуулж байна.

4.4. ТУЗ-ийн гишүүнд “хангалтгүй ажилласан” гэсэн дүгнэлт өгсөн бол үндэслэлээ бичгээр тайлбарлаж, тухайн гишүүний тайлбарыг авсан байна.

4.5. “Хангалтгүй” гэсэн үнэлэлт авсан гишүүний нэрийг дахин ТУЗ-д дэвшүүлэхгүй байх тухай болон “хангалтгүй” үнэлэлт авсан үндэслэлийг тайлбарласан албан тоотыг тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн этгээдэд хүргүүлнэ.

#### **ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

5.1. Энэхүү бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр өөрчилж, сайжруулж, хүчингүй болгож болно.

5.2. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажиллана.

5.3 ТУЗ нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор компанийн эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлагад шаардлага, зөвлөмж, чиглэл хүргүүлэх, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ТУЗ-ын тогтоол гаргаж аливаа хэлбэрээр арга хэмжээ авах бүрэн эрхтэй байна.

---oOOOo---